


## МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Ярилцлага өгөгчийн нэр	Шагдарсүрэн	Дугаар	L377
Оршин суугаа аймаг	Булган	Оршин суугаа сум	Гурванбулаг VI-р баг (сумын төв)
Төрсөн газар	мэдэгдэх	Төрсөн он	1944
Ажил мэргэжил	Тэтгэвэр авагч		
Лам байсан эсэх, Шавилан сууж байсан сүм хийд	үгүй	Сүм хийдийн дугаар	БУРТ 004, БУГБ 001 БУГБ 00, БУГБ 004 БУГБ 005, БУГБ 006 БУРТ 005, БУДЧ 001
Одоогийн сүм хийд		Сүм хийдийн дугаар	
Ярилцлага авсан он сар өдөр	25.08.2016	Ярилцлага авсан хүн	С.Дэмбэрэл



Шагдарсүрэн

**Өвгөн тарнийн өвгөн хийд** - уулынхаа хярд байж байгаа Галдан Бошигтын үед сүйтгүүлсэн, явган л очдог, морьтой бол ганц морьтны даваа гэдгээр л давж очих боломжтой сайхан газар байсан. Дараа нь Галдан Бошигтын үед сүйтгүүлчихээд Хөгнө хан гэдэг нэр нь тэр үеэс эхэлсэн. Үлдэгдэл Өндөр гэгээн урд Өвөр Монголд явж ирээд нөгөө олон өрх айлууд буцаж ирээд дахиад сэргээхдээ Жамсрангийн тахилгатай болсон. Дээр үед Ямандагийн тахилгатай байсан гэж ярьдаг. Их рашаантын аманд Жамсрангийн тахилгатай хийд байгуулсан нь одоо байж байгаа. Жамсрангийн хурлын бүх юмыг хариуцаж байх 60 өрхийг томилсон байдаг ч зарим настайчууд 60 өрх айл өөр газраас авчирсан гэж бас ярьдаг. Хуучны юмнаас арай эвдрэлгүй тэр үеийнхээрээ үлдсэн нь суварганы хүрд Улаан сахиусны дуган нь хадтай ууланд байсныг юу ч үгүй болгосон байдгийг сэргээж барьсан. Ийм 2 хийд байна, доод талынхыг нь залуу хийд, дээдэх нь Өвгөн хийд гэдэг.

**Шивэртийн сүм** - Домэй гэж номтой лам байсан хотод байдаг Нархажид сүмийг байгуулсан гол хүн. Энд нэг дуган барьсан, нэг суварга босгосон. Сумын төв дээр босгох хүсэлтэй байсан ч хөгшчүүл хуучин хурал байсан газар дээр босгоё гээд босгосон. Тэгээд одоо эзэнгүй дуган, суварга 2 болоод байна. Майдар гуай(архитекторч хүн) сайд байхдаа шивэртийн сүмийн модон дуган байсан гэрийг хүмүүс томилж нэгдлийн хөрөнгөөр зассан байдаг юм. Тэр нь одоо болтол бий.

## МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

**Долоон худгийн хурал**- дэнж дээр замын урд 2 суварга босгосон байдаг хурал байсны хойд талд. Тэр суварга хүүхдүүд нь аав ээжийнхээ дурсгалд зориулж босгосон. Далан давхар уулын ард.

**Толийн хурал** - бэрхийн хараат. Толийн ус гэж намагтай булагт байдаг.

**Бүүрийн/Батсуурийн хурал** - хуучин манай сумын төв байсан тэгж байгаад нүүгээд манай энд буусан 1965 онд. Дуган нь том модон гэр дуган байсан. Тэнд нь гэр склад хийж байгаад сум нүүсэн эргээд барих аргагүй болчихоор нь манайхны нэг дархан Онжоо гэж хүн модыг нь аваад зуны байшин болгож барьсан нь одоо байдаг. 1937 онд хаагдсан байдаг ч 37 оноос ч өмнө зарим хийдүүдийг болиулсан байдаг.

**Үйзэнгийн хурал** - Бэрхийн ард байдаг. Суварганы үлдэгдэл байсан тэрэн дээр манай эндхийн хүүхдүүд шинэ суварга босгосон намартаа хурал хуруулдаг. Суурийн үлдэгдэл гэвэл довжооны хэдэн чулуу л бий. Үйзэнгийн хурал Эрдэнэтолгойн хурал ч гэж хэлдэг - нэлээд эрт байгуулагдсан. 2 чулуун байшингийн баруун талынх нь баруун урагш халгай дотор суур нь бий.

**Эрдэнэхамбын хүрээ Эрдэнзууд харъяалагддаг.** Чадалтай ламтай цам харайдаг жижиг хүрээ байсан. Буурь нь Хишиг-Өндөр Бүүрэг 2-ын дунд бий. Хүмүүс 2 янзаар ярьдаг Нэгдүгээрт: Өндөр гэгээний багш Эрдэнэ цоржийг настай болоход нь зориулж хурал барьж өгсөн гэдэг. Хоёрдугаарт: Эрдэнэцорж биш Эрдэнэ хамба гэдэг хүн Эрдэнэ цоржоос дараа үеийн хүн юм шиг байгаа юм. Тэр хүний байгуулсан хүрээ, манай хошууны лам нар тэнд харъяалагддаг байсан юм гэлэг. Рашаантай. Тээр жил нэг наадам хийсэн гэж байсан. Яг алийнхийг бол би мэдэхгүй. Би буурийг нь багадаа л очиж үзсэн.

**Түдэв гүний хүрээгэж** Дашинчилэнд харъяалагддаг, түдэв гүний хошуу гэж байсан. Түшээт ханы хошуунаас тусдаа байсан. Хүрээний байшингуудын туурь сайн мэдэгддэг, шинээр нэг суварга босгосон байна лээ.

Манай аавын эцэг Осор гавж ч гэдэг, зарим хүмүүс Осор гэлэн ч гэдэг Эрдэнэ хамбын хүрээнд сууж байгаад сүүлдээ мал малласан, манай аавыг бас банди болгосон. Тэр үед тууль хайлдаг хүн ирсэн, лам банди нар хулгайгаар оройдоо очиж тууль сонсдог байсан жил гаран болоод цаг цөвүүн болж шашин ном доройтох үед тэр хүнийг явах болоход номоо оготны нүхэнд нууж орхиод аав ээждээ ч хэлэлгүй хүрээ явсан гэдэг. Тэгээд өвөө маань жил гарны дараа олж очиход нөгөө туульчтайгаа Жадрын гүүрний тэнд дулдуй барьчихсан нөгөө туульч нь тууль хайлаад байж байхад нь авч ирсэн гэдэг. Тэрнээс хойш ном үзээгүй гэдэг.